



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/38

Сангивадалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Энхдэлгэр (Засаг даргын Тамгын газрын дарга)
Нарийн бичгийн дарга:	Э.Ууганцэцэг (Газрын даамал)
Гишүүдэд:	А.Соёл-Эрдэнэ (Төрийн сангийн дарга)
	Д.Батбаяр (Байгаль орчны Улсын байцаагч)
	И.Дүрзээ (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	Г.Энхтайван (3-р багийн Засаг дарга)
	Я.Дэлгэрнасан (7-р багийн иргэний төлөөлөл)

2. Баг, хорооны иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хуулийн хугацаанд нэгтгэн эрэмбэлж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/135 дугаар тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ  О.БАЗАРРАГЧАА

202302176